



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар

A/118

Эмээлтөлгой

Г Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс  
урьдчилан сэргийлэх намрын нэгдсэн  
дархлаажуулалтын ажил зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.8, 30 дугаар зүйлийн 30.12, 31 дүгээр зүйлийн 31.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/297 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, мэдрэмтгий малын дархлаажуулалтын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2025 оны 10 дугаар сарын 01-25-ны өдрийг хүртэл хугацаанд хууль тогтоомж, заавар, зааварчилгааны дагуу технологит хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал сүргээ бэлэн байлгаж бүрэн хамруулах, малыг барьж бэхлэн мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах, дархлаа тогтох хүртэл 28 хоногийн хугацаанд малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл хийхгүй байхыг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдэд хориглосугай.

4. Малчид, мал бүхий иргэдэд, дархлаажуулалтын зар хүргэх ажлыг зохион байгуулахыг багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга, багийн Засаг дарга нарт, мэргэжил, арга зүйн заавар зөвлөмжөөр ханган, ажлын явцад байнгын хяналт тавьж, ажлын хэрэгжилт, дархлаажуулалтын баримт, материалыг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

642501179

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.







Сумын Засаг даргын ..... оны ..... дүгээр  
сарын .....-ны өдрийн .....-р  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн ахлагч: Д.Түмэнжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Ч.Цэдэвсүрэн (Багийн Засаг дарга)

Ж.Должинсүрэн (Багийн Засаг дарга)

Б.Гарьдсоном (Багийн Засаг дарга)

Б.Болормаа (Малын их эмч)

С.Нанжид (Малын их эмч)

Т.Уранчимэг (Малын их эмч)

Т.Ануударь (Тархвар зүйч)

Нарийн бичиг: С.Жаргалсайхан (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

\_\_\_\_\_оо\_\_\_\_\_

Сумын Засаг даргын 2025 оны 09 дүгээр  
сарын 30-ны өдрийн 7/118-р  
захирамжийн хоёрдугаар хавсралт



**ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ**

Д/д	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Дархлаажуулалтад хамрагдах		Олгох вакцин (тун)
		Өрх	Үхэр	
1	"Давхарын нуруу" МЭҮН	185	6000	6000
2	"Ар хаг" МЭҮН	192	7500	7500
3	"Буурал эг хайрхан" МЭҮН	278	14547	14547
<b>НИЙТ</b>		<b>655</b>	<b>28047</b>	<b>28047</b>

ооо